



“АЛТАЙН ЗАМ” ХК ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2015.04.04

№ 001

Улаанбаатар хот

САНАЛ ХУРААХ ХУУДСЫГ ТООЛСОН ДҮНГИЙН ТУХАЙ

Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 4 сарын 04-ний өдрийн ээлжит хуралдааны ирц, Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйл, 63.4 дэх заалт, 67 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд эчнээ байдлаар урьдчилан өгсөн саналын хуудас байхгүй болохыг дурьдсугай.

ХОЁР. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасны тооллогоор 50056 ширхэг саналын эрхтэй 1 ширхэг хүчинтэй саналын хуудас тоолсон бөгөөд хүчингүй саналын хуудас тоологдоогүй болохыг мэдэгдсүгэй.

ГУРАВ. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанаар хэлэлцсэн асуудал, хуралдаан болон санал хураалтын ирц, саналын хуудасыг үндэслэн хэлэлцсэн асуудалд өгсөн санал нь дараахи дүнд хүрсэн болохыг батласугай.

№	Хэлэлцсэн асуудал/ шийдвэрийн төсөл	Шийдвэрийн ирц	Татгалзсан	Түдгэлзсэн	Зөвшөөрсөн
1	Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт ХЭ2015001	50056 /92%	0	0	50056
2	ГУЗ-ийн 2014 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай/ ХЭ2015002	50056 /92%	0	0	50056
3	ГУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах, шинээр томилох тухай ХЭ2015003	50056 /92%	0	0	50056
4	ГУЗ-ийн гишүүдийн зардлын төсөв, Урамшууллын хэмжээ батлах тухай ХЭ2015004	50056 /92%	0	0	50056

ДӨРӨВ. Хүчинтэй саналын хуудсын Уг тогтоолд хавсаргасугай.

КОМИССЫН ДАРГА  **Б.ЭНХБАТ**



ТУ32015003 тоот тогтоолын хавсралт №3

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2015 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС

- 1. Хувьцаа эзэмшигчийн овог Дозурайт
- 2. Хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр Мянсуу
- 3. Хувьцаа эзэмшигчийн нэр Минсүхбаяр
- 4. Итгэмжлэлээр оролцож байгаа бол төлөөлөгчийн мэдээлэл Нарангос
Група г.м.к
- 5. Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар _____
- 6. Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар _____
- 7. Санал өгөх хувьцааны тоо 50056. ширхэг
- 8. Бүртгэсэн / брокер, диллер/ компанийн нэр _____
- 9. Брокерын овог, эр _____

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт	✓		
2	ТУ32015002 тоот тогтоолыг танилцуулах тайлбар хийх	✓		
3	ТУЗ-ийн 2014 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай	✓		
4	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай	✓		
5	ТУЗ-ийн гишүүдийн зардлын төсөв батлах тухай	✓		

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ М.М. / М. Минсүхбаяр /
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

Санал авах хуудсын ашиглах санамж

- Хувьцаа эзэмшигч нь хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсаар саналаа урьдчилан илгээж болно.
- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсан дахь тохирох хэсэгт + тэмдэглэл хийх бөгөөд нэг асуудалд нэг тэмдэглэгээ хийнэ.
- Засварласан болон балласан саналын хуудас хүчингүйд тооцогдно.
- Ээлжит хурлын талаархи мэдээллийг 976-70112251, 99155646, 99110374 тоот дугаарын утаснаас авах боломжтой

Саналын хуудас хүчингүй болсон тухай тэмдэглэл (шалтгаан) _____



“АЛТАЙН ЗАМ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015.04.04

№ ХЭ2015001

Улаанбаатар хот

2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ БАТЛАХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн 2015 оны 4 сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тооллогын комиссын 001 тоот тогтоолыг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Компанийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлттэй танилцан Тэгш Сан Аудит ХХК-ийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, ТУЗ-ийн танилцуулсан дүгнэлтийг батласугай.

ХОЁР. 2015 онд үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахыг ТУЗ-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



М.НЯМДАВАА



**“АЛТАЙН ЗАМ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015.04.04

№ ХЭ2015002

Улаанбаатар хот

ТУЗ-ийн 2014 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай

Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04 сарын 04-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.15 дахь заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. ТУЗ-ийн гишүүдийн 2014 оны үйл ажиллагааны тайланг үндэслэлтэйд тооцон, зөв гэж үзсүгэй.

ХОЁР. ТУЗ-ийн 2014 оны үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



М.НЯМДАВАА



“АЛТАЙН ЗАМ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015.04.04

№ ХЭ2015003

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг сунгах, шинээр томилох тухай

Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 4 сарын 04-ний өдрийн ээлжит хуралдааны тэмдэглэл, Тооллогын комиссын 001 тоот тогтоолыг үндэслэн, Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйл 77.1; 62 дугаар зүйл, 62.1.7 дахь заалт, Компанийн дүрмийн 7.7.5 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Хувьцаа эзэмшигчдийн дийлэнхи олонхийн саналыг авсан нэр бүхий 8 гишүүний бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчдийн 2016 оны ээлжит хурал хуралдах хүртэл хугацаагаар сунгасугай.

ТУЗ-ийн ердийн гишүүн

Сандагийн Баянчулуун

Сандагийн Баянмөнх

Маамуугийн Нямдаваа

Цэндсүрэнгийн Ганцэцэг

Норовын Энхцэцэг

Хараат бус гишүүн

Ганболдын Сономжамц

Дамбачүлтэмийн Байлхүү

Баярдалайн Бат-Ирээдүй

ХОЁР. ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт гаргасан С.Балжиннямын саналыг хүлээн авч 2015 оны 04 сарын 04-ний өдрөөс эхлэн ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

ГУРАВ. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооноос санал болгосон Сандагийн Алтантунгалагийг 2016 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаагаар ТУЗ-ийн гишүүнээр сонгосныг батламжилсугай.

ДӨРӨВ. ТУЗ-ийн гишүүнээр улиран сонгогдсон болон шинээр сонгогдсон гишүүдэд баяр хүргэж, Компанийн засаглалын зарчмыг баримтлан ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



М.НЯМДАВАА



“АЛТАЙН ЗАМ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015.04.04

№ ХЭ2015004

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хэмжээг батлах тухай

Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 4 сарын 04-ний өдрийн ээлжит хуралдааны тэмдэглэл, Тооллогын комиссын 001 тоот тогтоолыг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 62.1.13 дахь заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд сар бүр олгох урамшууллын хэмжээг тогтоолын хавсралт №1-д заасан ёсоор батласугай.

ХОЁР. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд олгох Хавсралт №1-д заасан урамшууллыг 2015 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаан хүртэл хугацаанд олгохыг Алтайн Зам ХК-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  М.НЯМДАВАА



**АЛТАЙ ЗАМ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Огноо:	2015.04.04	
Эхэлсэн цаг:	13:00	
Дууссан цаг:	14:45	
Хаана:	Улаанбаатар хот. СХД 4-р хороо, “Алтайн Зам” ХК – ийн хурлын танхим	
Хурлын төрөл:	<input checked="" type="checkbox"/> Ээлжит хурал	<input type="checkbox"/> Ээлжит бус хурал
Дугаар:		

Хурлын ирц

1	М.Нямдаваа	ТУЗ-ийн дарга	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
2	С.Балжинням	ТУЗ-ийн гишүүн	<input type="checkbox"/> ирсэн	<input checked="" type="checkbox"/> ирээгүй
3	Ц.Ганцэцэг	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
4	Г.Сономжамц	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
5	Б.Бат-Ирээдүй	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
6	С.Баянчулуун	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
7	С.Баянмөнх	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
8	Д.Байлхүү	ТУЗ-ийн гишүүн	<input type="checkbox"/> ирсэн	<input checked="" type="checkbox"/> ирээгүй
9	Н.Энхцэцэг	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй

ТУЗНБД Т.Мөнгөнцацрал: Алтайн Зам ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хуралдаанд 50056 ширхэг хувьцаа эзэмшигч Ньюпрогресс Групп ХХК-ийг итгэмжлэлээр төлөөлөн М.Нямдаваа оролцохоор бүртгүүлсэн байна. Өөр хувьцаа эзэмшигч хуралдаанд оролцохоор бүртгүүлээгүй бөгөөд урьдчилан санал ирүүлсэн хувьцаа эзэмшигч байхгүй болно.

ТУЗНБД С.Оюунгэрэл хурлын ирцийг танилцуулав.

	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Ньюпрогресс Групп ХХК-ийг төлөөлөн М.Нямдаваа	50056 ширхэг	92%
	Нийт	50056 ширхэг	92%

Хувьцаа эзэмшигчдийн хуралдааны ирц нь Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйл 69.1-д заасан нөхцлийг хангасан байх тул хуралдааныг нээж байна.

Хурлын дарга М.Нямдаваа:

Хуралд хүрэлцэн ирсэн эрхэм ТУЗ-ийн гишүүддээ баярлалаа. Энэ удаагийн ээлжит хуралд миний бие Хувьцаа эзэмшигч Ньюпрогресс Групп ХХК-ийг итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөн оролцож байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа шууд орёё.

Хурлын дарга М.Нямдаваа: ТУЗ-ийн ТУ32015001 тоот Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг дүгнэх тухай, ТУ32015002 тоот Ногдол ашгийн тухай, ТУ32015005 тоот санхүүгийн аудит хийх байгууллагыг сонгон гэрээ байгуулах эрх олгох тухай тогтоолуудыг тус тус уншин танилцуулав.

....Хувьцаа эзэмшигч болон хурлын даргын хувиар оролцож байгаа миний хувьд хэлэлцэх асуудалтайгаа бүрэн танилцсан байгаа. Тэгэхээр шууд санал хураалтаа эхлүүлээд явах нь зүйтэй байна.

С.Баянчулуун: Надад нэг танилцуулах зүйл байна. ТУЗ-ийн гишүүн С.Балжинням нь төрийн захиргааны алба хаших болсон тул ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт гаргасан байгаа. Нэр дэвшүүлэх хорооны

зүгээс С.Балжиннямын гаргасан хүсэлтийн дагуу түүнийг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх, С.Алтантунгалагийг-ныг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгох асуудлыг уг хурлар оруулж, тогтоолын төслийг бэлтгэсэн байгаа.

М.Нямдаваа: С.Алтантунгалагийн танилцуулгатай танилцсан. Мэдлэг туршлагын хувьд ТУЗ-ийн гишүүнээр сонгоход татгалзах зүйл байхгүй. Мөн С.Балжиннямыг чөлөөлөхийг дэмжиж байна. Ерөнхийдөө хувьцаа эзэмшигчид маань өөрсдөө ТУЗ-д ажилласан болохоор нэмж өөрсөддөө дахин тайлбарлах хэрэг алгаа тэгэхээр саналаа хураая.

Хурал зохион байгуулах болон тооллогын комиссын дарга санал хураалтыг эхлүүлж, 13:45 цагт тооллолын комиссын дүнг танилцуулав.

Т.Мөнгөнцацрал өнөөдрийн хуралдаанд эчнээ байдлаар санал өгсөн хувьцаа эзэмшигч байхгүй нийт 50056 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигч оролцлоо. Тооллогын комиссоос дараахи тогтоолыг гаргаж байгаа бөгөөд тогтоолд саналын хуудсыг хавсаргасан болно.

Дараахи тогтоолын төсөлд санал хураалт явууллаа.

Нийт 50056 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцон 1 ширхэг хүчинтэй саналын хуудас тоолоо. Хүчингүй болсон саналын хуудас байхгүй

	Хэлэлцсэн асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт	ХЭ2015001	50056	0	0
5	ТУЗ-ийн 2014 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай	ХЭ2015002	50056	0	0
6	ТУЗ-ийн 8 гишүүний бүрэн эрхийг сунгаж, С.Балжиннямыг чөлөөлөх, -ыг сонгох тухай	ХЭ2015003	50056	0	0
7	ТУЗ-ийн гишүүдийн зардлын төсөв батлах тухай	ХЭ2015004	50056	0	0

Шийдвэрлэсэн нь .

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар

ХЭ2015001, ХЭ2015002, ХЭ2015003, ХЭ2015004 тоот тогтоолын төслийг 100 хувь дэмжин тогтоол гаргаж, энэ тухай холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг ТУЗНБД-д үүрэг болгов.

Хурлын дарга М.Нямдаваа: Энэ удаагийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал хурааж дууссан тул хуралдааныг хааж байна.

Хуралдаан 2015 оны 04 сарын 04-ны 14:46 цагт өндөрлөв.

ТУЗНБД
ХЯНАСАН
ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН
Т.МӨНГӨНЦАЦРАЛ
М.НЯМДАВАА



“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015.04.04

№ ТУЗ2015010

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ДЭД ХОРООДЫГ БАЙГУУЛАН ДАРГА, ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2015 оны 4 сарын 4-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйл, 78.1 дэх заалт, 79 дүгээр зүйл, 81 дүгээр зүйл 81.2 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн ХЭ2015003 тоот тогтоолыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Алтайн Зам ХК-ийн ТУЗ нь дэргэдээ дараахи хороодтой байхаар тогтоосугай..

- Аудитын хороо
- Нэр дэвшүүлэх хороо
- Цалин урамшууллын хороо

ХОЁР. Дэд хороодын дарга болон гишүүдийг дараахи бүрэлдэхүүнтэй томилсугай.

- Аудитын хорооны дарга	ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Бат-Ирээдүй
Аудитын хорооны гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Байлхүү
Аудитын хорооны гишүүн	ТУЗ-ийн гишүүн С.Баянмөнх
- Нэр дэвшүүлэх хорооны дарга	ТУЗ-ийн гишүүн С.Баянчулуун
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	ТУЗ-ийн гишүүн С.Алтантунгалаг
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Сономжамц
- Цалин, урамшууллын хорооны дарга	ТУЗ-ийн гишүүн Ц.Ганцэцэг
Цалин, урамшууллын хорооны гишүүн	ТУЗ-ийн гишүүн Н.Энхцэцэг
Цалин, урамшууллын хорооны гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Бат-Ирээдүй

ГУРАВ: Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар гишүүдийн дийлэнх олонхийн саналыг авсан М.Нямдавааг улируулан сонгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА